

2. Дсэрх зөвшөөрөл шаардагдахгүй тохиолдол:

а/ хусэлт яБуулж байгаа Хэлэлиэн Тохирогч Этгээдийн харьяат биш шилжуулэн өгсөн этгээд тууний хэргийн мөрдөн байцаалт дууссан өдрөөс буюу хэрэв шийтгэгдсэн бол ялаа эдэлж дууссан, эсхул суллагдсан өдрөөс эхлэн нэг сарын дотор уг Хэлэлиэн Тохирогч Этгээдийн нутаг дэвсгэрээс гарч яваагүй бол; Хэлэлцэн Тохирогч Этгээдийн нутаг дэвсгэрээс гараагүй явдал өөрий нь буруугаас болоогүй бол уг саатсан хоногийг дээр дурдсан хугацаанд оруулахгүй.

б/ шилжуулэн өгсөн этгээд шилжуулэн өгөх хусэлт явуулж байгаа Хэлэлиэн Тохирогч Этгээдийн нутаг дэвсгэрээс явсан атал сайн дураараа буцаж ирсэн бол.

Наян долдугаар зүйл

Эрүүгийн мөрдөн байцаалт явуулсны дунг мэдэгдэх

Шилжуулэн өгөх шаардлага явуулж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээд шилжуулэн өгсөн этгээдэд иөрдөн байцаалт явуулсан дунгээ уг шаардлагыг хулээн авч байгаа Хэлэлцэч Тохирогч Этгээдэд мэдэгдэнэ. Шилжуулэн өгсөн этгээд хэрэв шийтгэгдсэн бол шуухийн хучик төгөлдөр болсэн 1эгтсэлын хувийг явуулна.

Наян наймдугаар зүйл

Шилжуулэн өгөх

I. Шилжуулэн өгөх шаардлагыг хулээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээд уг шаардлагыг явуулж байг за Хэлэлцэн Тохирогч Этгээддээ хэдийд, ямар иизраар хэрэгтнийг шилжуулэн өгөхөө иэдэгдэнэ.